

2020 он 1 сар 10 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-д

### Тайлбар хүргүүлэх тухай

Энэ өдрийн амгаланг айлтгая.

Ард Кредит ББСБ ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн билээ.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэн үндэсний төлбөрийн системтэй холбоотой бүх асуудалд Монголбанк хяналт тавихаар болсон билээ.

Манай компанийн харилцагчиддаа үзүүлж буй төлбөр төлөх, мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах зэрэг үйлчилгээ нь тус хуулийг батлагдахаас өмнө Санхүүгийн зохицуулах хорооны Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлд хамаарах боломжтой байсан юм. /Ард Кредит ББСБ ХК 2018 онд Санхүүгийн зохицуулах хорооноос Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан болно/

Үүнтэй холбогдуулан бидний харилцагчиддаа үзүүлж буй дээрх үйлчилгээ нь Монголбанкнаас тусгай зөвшөөрөл хүсэх шаардлагатай үйлчилгээ мөн эсэх дээр Монголбанкнаас тодруулга хүсэхэд Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах шаардлагатай гэсэн хариу өгсөн тул 2019 оны 9 сард Монголбанкинд Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаад байна.

Бидний тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт, баримт бичгийг Монголбанкнаас хянаж үзэн нэмэлт материал ирүүлэхийг хүссэн бөгөөд шаардлагатай материалуудыг хүргүүлэхээр ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.СҮХБААТАР